

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2020 оны 06 дугаар сарын 15

Багануур дүүрэг

№	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая.төг/, хөрөнгийн эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	Үнэлгэний хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРТ								
1.1. Үйлдвэрлэл, инновацийг цогцоор нь хөгжүүлнэ.								
1-4	1.1.1.4. Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ.	“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн ажлыг барьж байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.	НШУУИГ, НХБХГ, БҮТП ОНӨТҮГ	Хүнд үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн асуудлын шийдвэрлэлт хувь	100	Төр, хувийн хэвшлийн түншлэл		
			НШУУИГ, НХБХГ, БҮТП ОНӨТҮГ	Цахилгаан хангамжийн ажлын явц, хувь	50	9,376.9 Гадаадын эх үүсвэр		
		<p>1. 2020 оны Нийслэл болон Улсын төсвөөс Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад ямар нэгэн хөрөнгө санхүүжилт олгогдоогүй. Дүүрэг болон Нийслэлийн засаг дарга нарт боломжтой нөхцөлүүдийг танилцуулан үүрэг чиглэл аван, дэс дараатай арга хэмжээ авч ажилласнаар Паркийн цахилгаан эрчим хүчний ерөнхий хангамжийн 7,3 км 110/35/10 кВ-ын ЦДАШ-ыг Багануур дүүрэгт төмөрлөгийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа “МЕСЕС” ХХК-тай хамтарсан хөрөнгө оруулалтаар байгуулах гэрээг 2020.02.06-ны өдөр байгуулан ажиллаж байна. “МЕСЕС” ХХК нь эхний ээлжинд өөрийн хөрөнгөөр дээрхи бүтээн байгуулалтыг хийж паркийн өмчид 100% хүлээлгэн өгөх юм. Энэхүү төсөл хэрэгжснээр БҮТП-д эхний ээлжинд хүнд үйлдвэрийн чиглэлийн</p>						

		<p>2 үйлдвэр, “Адуу” брэндийн өргөтгөлийн ажлыг эхлүүлэх боломжтой болох ба мөн 80 гаруй ажлын байр шинээр бий болгохоор зорьж байна.</p> <p>2. 04 дүгээр сард Газрын дарга нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэн БХБЯ, БХТ, ЭХЯ, Диспетчерийн үндэсний төвтэй уулзалт зохион байгуулан техникийн нөхцөлд тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн зөвлөсний дагуу Багануур 220/110/35 кв-ын дэд станцийн 110 кв-ын талаас хангуулахаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аар цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог гүйцэтгүүлэн 2020.05.27-нд хүлээн авсан. Мөн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Зүүн Өмнөд бүсийн салбарын холбогдох инженер техникийн ажилтнуудтай уулзалт хийж цахилгаан хангамжийн холболтын схем болон хэрэглээ ачаалалын гаргалгааг зөвшилцөв. 2020.06.09-ний өдөр ЭХЯ-д дээрхи ЦДАШ-ыг байгуулах тухай техникийн нөхцөл цахим хэлбэрээр хүсэж холбогдох материалуудыг оруулав.</p> <p>3. БҮТП-ийн дэд бүтэц, нийтийн барилга байгууламж болон ногоон байгууламжуудыг байгуулах хөрөнгө оруулалтын төслийг 2020-2025 он хүртэлх хугацаагаар нарийвчлан тооцон гаргаж, 2021 онд хэрэгжүүлэх төслүүдийн саналуудыг салбарын яамдуудад 2020.01.24-ний өдрийн 15, 02.07-ны өдрийн 24, 04.22-ны өдрийн 73, 04.27-ны өдрийн 75, 06.03-ны өдрийн 100, 102 дугаартай албан бичгүүдээр тус тус уламжилсан.</p> <p>4. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Лхамсүрэнгийн удирдлага зөвлөмжийн дагуу паркийн 2020-2025 онд хэрэгжих төсөл арга хэмжээнээс нэн чухал шаардлагатай 6 төслийг 2021 оны Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд Сангийн сайдын 2018 оны 95-р тушаалаар баталсан журмын дагуу үнэлэн, эрэмбэлэн оруулж ажиллалаа.</p> <p>5. “Багануур” ХК-ийн үйлдвэрийн бүсийн дэд бүтцийг түшиглэн Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүнд үйлдвэрийн бүсийн бүтээн байгуулалтад шаардлагатай зардал, төсвийг бууруулж, цаг хугацааг хэмнэх үүднээс “Багануур” ХК-тай хамтран ажиллах боломжийг судалж, зарим шаардлагатай техникийн өргөтгөл хийж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар эрчим хүч, дулаан, төмөр зам болон авто замыг ашиглах судалгааны ажил хийж байна. “Багануур” ХК-тай хамтран ажиллах нь олон талт ашигтай боловч, мөн үүсч болох эрсдэлүүдийг маш нарийвчилсан түвшинд тодорхойлох нь чухал байна.</p> <p>6. Паркуудийн үйл ажиллагааг эрчимжүүлэх томоохон ажлуудыг зохион байгуулж, хамтран ажиллах зорилготой Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газрын дарга Б.Мөнх-Оргилд байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн үр дүн, цаашдын зорилго, зорилтууд мөн тулгамдсан асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 29 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>		
--	--	---	--	--

	7. БҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын төслүүдийг хүлээн авах, бүтээн байгуулалтыг эхлүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор БХБЯ, ЭХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ-дад хамтран ажиллах тодорхой саналуудыг хүргүүлэн ажиллаж байна.		
	Дундаж хувь	50%	

БИЕЛЭЛТ ХЯНАСАН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Lanwit

Б.НОМИНЗУЛ